



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 2/716

Баруун-Урт сум

Барилга байгууламжийг байнгын
ашиглалтад оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Дүрэм шинэчлэн батлах тухай” дүрмийн нэгдүгээр хавсралтын 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Баруун-Урт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Олимп апартмент” хотхоны 40 айлын орон сууцны барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Э.Төгөлдөр	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	М.Төрбаяр	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга
	Б.Алтансүх	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	С.Оюухорол	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
	С.Балжинням	- Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Баатарцогт	- Мэргэжлийн хяналтын газрын барилга техникийн хяналтын улсын байцаагч
Э.Мөнхнаран	- Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
Ш.Түдэвдорж	- Мэргэжлийн хяналтын газрын авто тээвэр, өргөх машин механизмын хяналтын улсын байцаагч
Б.Баярсайхан	- Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад
С.Сайнзаяа	- “ДБЭХС” ТӨХК-ний Сүхбаатар аймаг дахь салбарын ерөнхий инженер
Б.Ананд	- “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ний Сүхбаатар салбарын ерөнхий инженер
Ч.Алдарбат	- “Дөрвөлж” /ОНӨ/ ХХК-ний ерөнхий инженер
М.Хүрэлтогоо	- Баруун-Урт сумын 3 дугаар багийн Засаг дарга
Б.Бат-Оргил	- “Голден Би Ти Эс констракшн” ХХК-ний захирал (захиалагч)
Э.Алтан-Од	- “Алтан-Орд констракшн” ХХК-ний захирал (зохиогч)
Ж.Отгонжаргал	- “Гурван эрдэнэ констракшн” ХХК-ний захирал (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: С.Наранчулуун	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Комиссыг бүрэн бүрэлдэхүүнээр хуралдуулж, холбогдох хууль, дүрэм, журам, тогтоомжийн хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг комисс /Э.Төгөлдөр/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ